



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/36

Баян-Овоо сум

**Үндсэн хөрөнгийг данс бүртгэлээс
хасах тухай**

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дугаар зүйлийн 31.1 дэх заалт, Хэнтий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2020 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах шилжүүлэх журам", Хэнтий аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 192 дугаартай албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндсэн хөрөнгийн данснаас 335 нэр төрлийн 2138 ширхэг 24,911,514.80 (хорин дөрвөн сая есөн зуун арван нэгэн мянга таван зуун арван дөрвөн төгрөг наян мөнгө) төгрөгийн балансын үнэтэй үлдэх өртөггүй хөрөнгийг данс бүртгэлээс хасахыг нягтлан бодогч (Г.Баасансүрэн)-д даалгасугай.
2. Эд хөрөнгийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.
3. Сургуулийн өмч хамгаалах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн данснаас хасахыг аж ахуйн нярав (Т.Хэрлэнчимэг), нягтлан бодогч (Г.Баасансүрэн) нарт үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Ч.БОЛОРМАА